

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1. Төслийн товч тодорхойлолт	3
1.2 Үйл ажиллагааны чиглэл.....	7
1.3. Төслийн түүхий эд, бүтээгдэхүүн.....	17
3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	23
3.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ	23
3.2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	23
3.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	23
3.4. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	23
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	24
5. НОГООН БАЙГУУЛАМЖ БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, ТЭРБУМ МОД ХӨТӨЛБӨР	27
6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	28
7. ХИМИЙН БОДИС ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	28
8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	28
10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	30
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	31
12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	35
13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ	36

Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол	3
Хүснэгт 2. Автоклав, Техникийн дэлгэрэнгүй мэдээлэл	11
Хүснэгт 3. Шатаах зуух, Техникийн дэлгэрэнгүй мэдээлэл	13
Хүснэгт 4. Ортой эмнэлэгүүдээс гарах хаягдлын хэмжээ	17
Хүснэгт 5. Эмийн сан, Эм ханган нийлүүлэх байгууллагуудаас гарах хаягдлын хэмжээ	17
Хүснэгт 6. Амбулаторит эмнэлэгүүдээс гарах хаягдлын хэмжээ	19
Хүснэгт 7. Нийт эмнэлэгүүдээс гарах хаягдлын хэмжээ	19
Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	25
Хүснэгт 9. Ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө	27
Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	29
Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	32
Хүснэгт 12. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	35
Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь	36
Хүснэгт 14. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт	37

Зургийн жагсаалт

Зураг 1. Талбайн байршлын тойм зураг.....	4
Зураг 2. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламж.....	4
Зураг 3. Үйлдвэрийн процесс	7
Зураг 4. Устгалын дараалал /схем/	8
Зураг 5. Ялган ангилах савнууд.....	9
Зураг 6.Авто клав	11
Зураг 7.Шатаах зуух	13
Зураг 8. Төсөл хэрэгжих талбайн гадаргын төрх байдал, урдаас	15
Зураг 9. Төсөл хэрэгжих талбайн гадаргын төрх байдал, баруунаас	15
Зураг 10. Төсөл хэрэгжих талбайн гадаргын төрх байдал, хойноос	15
Зураг 11. Төсөл хэрэгжих талбайн гадаргын төрх байдал, зүүнээс	16
Зураг 12. Ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө, 2025 он.....	27
Зураг 13. Мониторингийн байршлын зураг	34

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн товч тодорхойлолт

Төслийн нэр: Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламж

Хэрэгжүүлэгчийн нэр: “Санди Тис” ХХК

Регистрийн дугаар: 3064484

Хэрэгжүүлэгчийн хаяг: Баян-Өлгий аймаг Өлгий сумын 6-р баг Жаргал 26-н 2609 тоот

Төслийн зорилго, зорилт: Орон нутгийн эмнэлгүүдээс ялгарч буй эрүүл мэндийн аюултай хог хаягдлыг цуглуулах, халдваргүйтэх, хадгалах, тээвэрлэх, устгах зэрэг одоогийн хийж буй үйл ажиллагаагаа өргөжүүлэх

Эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэн байгаль орчинд ээлтэй хор нөлөөгүй арга технологи ашиглан дэлхийн стандартын дагуу үйл ажиллагааг явуулах бөгөөд ЭМСайдын 505 тоот тушаалын стандартын дагуу баригдсан зориулалтын байртай.


24 цагийн интернеттэй 4G IP хяналтын камерт холбогдсон аюултай хог халдваргүйжүүлэн устгах үйл явцыг хянах төвийн удирдлагатай компани юм. Төв удирдлагын байгууллагад мэргэжсэн мэргэжилтэн аюултай хог халдваргүйжүүлэн устгах үйл явцыг хянаж, баримтжуулна.Төлбөр тооцоог улирал тутамд 1 удаа, жилд 4 удаа цахимаар хийж баталгаажуулна. Цагт 500кг аюултай хог халдваргүйжүүлэн ариутгах хүчин чадалтай 8 м³ багтаамжтай автоклав. Цагт 150 кг аюултай хог бутлах хүчин чадалтай бутлуур буюу шредер, хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий олон дамжлагат шүүлтүүртэй утаагүй зуух юм.

Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол

№	X	Y	Урт
1	717386.33	5433796.00	174.27
2	717407.20	5433623.12	84.72
3	717491.98	5433627.59	152.20
4	717499.28	5433779.50	113.92

Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Зураг 1. Талбайн байршлын тойм зураг



Зураг 2. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламж





Хана шал нь битүү цементлэгдсэн зориулалтын ихсийн нүхэн байгууламж. Эмнэлгийн аюултай хог хаягдлыг тусгай таних тэмдэгтэй, битүүмжлэгдсэн, тусгай хөргөлтийн системээр тоноглогдсон GPS системтэй холбогдсон мөн тусгай тэмдэглэгдсэн маршруттай автомашинаар хог хаягдлыг устгах үйлдвэрт тээвэрлэнэ.

Аюултай хог хаягдлыг эмнэлгүүдээс Төв байгууллагаас гаргасан цагийн хуваарь болон графикийн дагуу аюултай хог хаягдлыг цуглуулна.

Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламж нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр эрүүл, аюулгүй орчинд ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэн байгаль орчин, эрүүл мэндийн салбарт компанийнхаа хувь нэмрийг оруулж, хүн амын эрүүл мэнд болон байгальд хор нөлөөгүй, ээлтэй арга технологийг ашиглан стандартын дагуу дараах үйл ажиллагаа хийж эхэлнэ.

Эмнэлгийн аюултай хог хаягдалд:

- Хурц үзүүртэй, иртэй хог хаягдал: Хүний арьс салстыг хатгаж гэмтэл учруулж болохуйц бүх хог хаягдал орно.
- Халдвартай хог хаягдал: Хүний цус, хэрэглэсэн бээлий, маск, малгай, цэр, өтгөн шингэн г.м бохирлогдсон зүйлс орно.

Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

- Эмийн хог хаягдал: Хугацаа дууссан, хэрэглэхийг хориглосон, хагарч гэмтсэн, биобэлдмэл, вакцин, мансууруулах болон сэтгэц нөлөөт эм, бодис агуулсан сав, тун шил, хайрцаг г.м орно.
- Халдварын зэрэг өндөртэй хог хаягдал: Голомтот халдварт өвчнүүд цар тахалт өвчнүүд, сүрьеэ, БЗХӨ үед хэрэглэсэн болон лабораториос үүссэн хог хаягдал.
- Эмгэг хог хаягдал: Мэс ажилбар, задлан шинжилгээний явцад гарсан биеийн хэсэг, тайрсан эд эрхтэн ,ихэс, зулбадас.
- Химийн бодисын хог хаягдал: Хатуу ,шингэн хий байдалтай лабораторийн хаягдал, ариутгалын бодис, рентген зургийн зальс бэхжүүлэгч, хугацаа дууссан химийн бодисууд.
- Эсэд хортой нөлөөтэй хог хаягдал: Хавдрын эмчилгээний үеэ хэрэглэгддэг эсэд хортой нөлөө үзүүлдэг эм, эмийн үлдэгдл, тэдгээрийг агуулж байсан сав, тун шил, хайрцаг.
- Цацраг идэвхит хог хаягдал: Ионжуулагч цацраг бүхий радионуклидууд агуулсан цацраг идэвхит шинж чанар бүхий хатуу , шингэн, хийн хаягдал.
- Хүнд металлын хог хаягдал: Хэрэглээнээс гарсан халууны шил, даралтын аппарат .
- Даралтат сав шахсан хий, шингэн,нунтаг агуулсан бортогон хэлбэртэй цилиндр эсвэл аэрозольтой савнууд.
- Эрүүл мэндээс гарч буй аюултай (Химийн лабораторитой сургууль, аюултай хог хаягдал үйлдвэрлэдэг бусад байгууллагууд бас орно.) хог хаягдлаас учрах хохирол тооцвол Хүрээлэн буй орчинд агаар, ус булаг, шанд, гол, мөрөн, хөрсийг бохирдуулах, Халдвартай өвчин тарах үндэс болж хүн эрүүл мэндээр хохирох зэрэг асар их хор хөнөөлтэй.

Яг одоогийн байдлаар Баян -Өлгий аймагт Эрүүл мэндийн байгууллагуудаас гарч буй аюултай хог хаягдлыг тээвэрлэж, халдваргүйжүүлэн устгах цогц менежменттэй аж ахуйн нэгж, компани байхгүй. Коронавируст халдвар(Ковид -19) өвчин тархсан энэ үед аюултай хог хаягдал тэр дундаа халдвартай хог хаягдал ихээр гарч буй үе сэтгэл эмзэглүүлэх нэг том асуудал мөн. Ттиймээс эрүүл мэндийн байгууллагуудаас гарч буй аюултай хог хаягдлыг цэгцлэх тээвэрлэх халдваргүйжүүлэн устгах маш том цогц менежменттэй шийдэл хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр


1.2 Үйл ажиллагааны чиглэл

- Эрүүл мэндийн байгууллага, жижиг дунд үйлдвэр, сургуулиудаас гарч буй тусгай аюултай хог хаягдлыг тээвэрлэх, зөөвөрлөх, ариутган халдваргүйжүүлэх, бутлах, ландфилл хийж устгах үйл ажиллагааг гүйцэтгэн ажиллаж байна.
- Устгалд оруулах боломжгүй аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь зөв хадгалах, цуглуулахад заавар зөвлөгөө өгөх
- Ахуйн хог хаягдлыг тээвэрлэх, ангилан ялгах, ландфилл хийх (үйлдвэрлэлийн хог хаягдлыг аюулгүй болгох)
- Эрүүл мэндийн байгууллагуудын аюултай хог хаягдал хог хаягдал ариутган халдваргүйжүүлэх автоклавын ариутгагч бэлдэх, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах

Аюултай хог хаягдлыг устгах дараалал


1. Хог хаягдлыг цуглуулах
2. Тээвэрлэх
3. Ариутган халдваргүйжүүлэх
4. Бутлах
5. Шатаах
6. Булах ландфилл

Зураг 3. Үйлдвэрийн процесс



Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Зураг 4. Устгалын дараалал /схем/



Хог хаягдлыг цуглуулах



Аюултай хог хаягдлыг цуглуулах

Эмнэлгийн болон эрүүл мэндийн байгууллагын оношлогоо, эмчилгээ, үйлчилгээний явцад үүсэх хүн, амьтны бие, эрхтэн, эд, хэсэг, бичил биетийн өсгөвөр, цус бусад шингэн, ялгадас, эм эмийн бүтээгдэхүүн, био бэлдмэл, зүү тариур, хурц үзүүртэй, иртэй багаж хэрэгсэл, химийн болон цацраг идэвхт бодис зэрэг хаягдлыг үүссэн газарт нь тусгай зориулалтын био-аюулгүйн таних тэмдэг бүхий таних тэмдэгтэй уут, хогийн саванд хийж түр хадгалах байр эсвэл цэгт байршуулна. Зориулалтын хогын сав тарааж цуглуулж авна.

Хог хаягдлын уут дараах шаардлагыг хангасан байна

Амархан цоорч гэмтэхгүй, шингэн нэвчихгүй, хлор агуулагүй нийлэг материалаар хийгдсэн,

Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

7 микроноос багагүй зузаантай (ISO 7765:2004) уутыг ашиглана. Хог хаягдлын уут тус бүрийн ангилалд тохирсон өнгөтэй байх бөгөөд халдвартай, эмгэг, хурц үзүүртэй хог хаягдлын уут сав нь шар өнгөтэй, эмийн болон эсэд нөлөөтэй, химийн, цацраг идэвхит хог хаягдлын уут улаан хүрэн өнгөтэй, уут сав тус бүрт таних тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан байна. Дээрх шаардлагыг хангасан аюултай хог хаягдлын уут, савыг зориулалтын машинаар тээвэрлэхэд бэлэн болгож бэлтгэнэ.

Зураг 5. Ялган ангилах савнууд



Тээвэрлэх

Таних тэмдэг эмблэмтэй битүүмжлэгдсэн тээвэрлэлтийн машин.



Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг зориулалтын бат бэх, амархан цоорохооргүй, нүх сүвгүй, шингэн нэвчихгүй, таглаатай хуванцар саванд хийж, замын хөдөлгөөнд оролцох шаардлага бүрэн хангасан, тусгай таних тэмдэгтэй, битүүмжлэгдсэн, тусгайлан тоноглогдсон авто машинаар өвлийн улиралд 72 цаг, дулааны улиралд 48 цагийн дотор тээвэрлэнэ.


Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх явцад хэрэглэсэн 1 удаагийн хуванцар багаж хэрэгсэл ,гуурс, толь, бээлий, маск, малгай , хуучирсан цагаан хэрэгсэл орно.

Хог хаягдлын тээвэрлэх тээврийн хэрэгсэл дараах шаардлагыг хангасан байна

- Жолоочийн кабин болон ачааны хэсэг хоорондоо тусгаарлагдсан байх
- Машины дотор тал нь цэвэрлэж халдваргүйжүүлэх боломжтой байх
- Стандартын шаардлага хангасан хувийн хамгаалах хэрэгсэлтэй байх
- Шингэн зүйлс гоожиход авах арга хэмжээний заавар, цэвэрлэх хэрэгсэл, халдваргүйжүүлэгч бодис, хоосон нийлэг уут, бээлий, амны хаалт, шингээгч алчуур, хүрз зэрэг цэвэрлэгээний багажтай байх,
- Хор саармагжуулах бодис, уусмал зэрэг байх
- Тээвэрлэлтийн явцад болзошгүй аюул учирсан тохиолдолд хэрэглэх, хор уршгийг арилгах зориулалтын багаж, гал түймэр унтраах хэрэгсэл /галын хор, хүрз, шуудайтай элс, хувин г.м/
- Яаралтай тохиолдолд хэрэглэх засварын хэрэгсэл
- Машины хүндийн жин, дугуйны хэмжээнд тохирсон зогсоогч (механик тоормос)
- Цахилгаанаас хамааралгүй асдаг 2 ширхэг шар гэрэл зэрэг болно.

Ариутган халдваргүйжүүлэх

Аюултай хог хаягдлыг ариутган халдваргүйжүүлэх



Эмнэлгийн аюултай хог хаягдлыг өндөр даралтад уур үүсгэгч Автоклав гэж нэрлэгдэх тоног төхөөрөмжөөр халдваргүйжүүлнэ. Хог хаягдлын уут, савны бүрэн бүтэн байдлыг сайтар шалгаж автоклавын дотор хананд ямар нэгэн эд зүйлийг тулган тавихгүйгээр уут савтай хог хаягдлыг сийрэг байрлуулна. Овор ихтэй, хүнд жинтэй хог хаягдлыг доод хэсэгт байрлуулна.

Автоклавт хог хаягдал материалын төрөл, хэмжээ зэргээс хамааран халдваргүйжүүлэх хугацаа, халууны хэм өөр өөр байна. Аюултай хог хаягдлыг автоклавт 121°C-ын хэмд 20 минут, 134°C-ын хэмд 10 минутын хугацаанд халдваргүйжүүлнэ. Автоклавын халдваргүйжүүлэлтийн чанарыг өндөр даралтат уурын өнгөний хувиралтай туузан индикатороор хяналт тавина.

Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Зураг 6.Авто клав



Хүснэгт 2. Автоклав, Техникийн дэлгэрэнгүй мэдээлэл

Загвар	IGZGS
Автоклавын даралт	0.07 МПа
Автоклавын температур	+114 в
Автоклавын жин	2000кг
Халдваргүйжүүлэх мөчлөгийн хугацаа, минут	60
Нийт хэмжээ	100x110x700 см
Автоклавын гүйцэтгэл	7m ³ /цаг

Үндсэн шинж чанарууд ба давуу талууд:

- Энгийн байдал, аюулгүй байдал, байгаль орчинд ээлтэй байдал
- Ажилтны зардлыг бууруулахын тулд хагас автомат болон автомат дамжуулах шугамууд байдаг
- Үнэр дарах дэвшилтэт технологи нь тав тухтай орчныг бүрдүүлдэг
- Засвар үйлчилгээний зардал бага
- Үйлчилгээний хугацаа - дор хаяж 15 жил

Эмнэлгийн хог хаягдал боловсруулах төвүүдэд зориулсан шийдэл

Эмнэлгийн хог хаягдлыг боловсруулах төвлөрсөн систем нь ойр орчмын эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн бүх төрлийн эмнэлгийн хог хаягдлыг, боловсруулах, устгах боловсруулах үйлдвэрүүдэд ашиглагддаг.

Хог хаягдлыг бутлах



Аюултай хог хаягдлыг бутлах

Автоклавт ариутган халдваргүйжүүлсэн болон бусад хог хаягдлын овор хэмжээ, байгальд хурдан задрах процессыг нэмэгдүүлэх, эрсдэлийг багасгах зорилгоор буталж жижиглэн, тусгай бэлдсэн олон улсын стандарт шаардлагад нийцсэн, холбогдох хууль, журмын дагуу батлагдсан булж устгахад зориулан бэлтгэсэн талбай зөөхөд бэлтгэнэ. Тус үйлдвэрийн хог хаягдлын бутлан жижиглэх зориулалттай бутлагч төхөөрөмж нь цагт 250кг,

өдөрт 1.5-3тонн хог хаягдлыг бутлах хүчин чадалтай.

Бутлагч машин

Энэхүү машин нь хайлшин ган, хийжүүлсэн ундааны сав, хөнгөн цагаан хийц, аккумулятор зэрэг хөнгөн цагаан, ган, ферромарганец, цинк, цахиур материалаар хийсэн хаягдлыг бутлах зориулалттай.

Шатаах



Шатаах зуух 900-1100 С-д биологийн гаралтай хог хаягдлыг шатаах хүчин чадалтай. Нэмэлт үлээх болон сорох сэнстэй, температур ихэсгэх, утааг дахин шатаах зориулалтын 2 дизел буутай.

Эмнэлгийн шатаах хог хаягдал:

Нэг удаагийн тариур, дуслын систем, хөвөн, самбай даавуу, мэс заслын хэрэглэгдэхүүн, резин бээлий, эмнэлгийн халаад, хамгаалалтын хувцас, ор дэрний цагаан хэрэглэл болон бусад халдварт хангамжийн бүтээгдэхүүнүүдийг шатаахад ашиглагдана.

Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Зураг 7.Шатаах зуух



Хүснэгт 3. Шатаах зуух, Техникийн дэлгэрэнгүй мэдээлэл

Загвар	LDF-500
Шатаах хүч (өдөрт 6 цаг)	300-400 кг/цаг
Шатагчийн хэмжээ (М) (L * Н * b)	1,2*1*2
Яндан (мм)	Ø460 (гадна диаметр)
Шаталтын температур °С	800-1200
Яндангийн өндөр	4 метр
Дизель түлшний дундаж хэрэглээ, цагт литр	5-8
Ажиллаж байгаа хүчдэл	380V
Жин, кг)	1450
Шатаах арга :	Дизель / хийн насос 1.1 кВт
Шатаах камерийн эзэлхүүн М³	2.5
Үндсэн шатаагчийн тоо	2
Шатаалтаас гарсан үнсний масс үлдэгдэд нь, %	4.5-аас ихгүй

Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Онцлог:

1. утаагүй, үнэргүй, хоёрдогч бус бохирдолтой
2. Шаталтын тохируулга хийх шаардлагагүй, аяндаа шатдаг (үнэ цэнэ: 3000ккал/кг), уур сэргээгдэх, дулаан үүсгэх хий.
3. Хөрвүүлэгчийн ашиглалтын хугацаа 8-10 жил.
4. Тэг гэмтэл: эвдрэлийн түвшин бага, засвар үйлчилгээний зардал.
5. Ашиглахад хялбар: сурахад хялбар, шатаахад хялбар, эрчим хүч хэмнэх.
6. Даралтат загвар, гал түймэргүй, тогтвортой эрчим хүч, том боловсруулах хүчин чадалтай.
7. Аюулгүй байдал өндөр: тэсрэлтгүй, ус, цахилгааныг автоматаар хаах систем, анхааруулах системд зориулсан нээлттэй загвартай.

Шатаах материал:

1. Эмнэлгийн хог хаягдал: тариур, бээлий, боолт, самбай, дусаах иж бүрдэл
3. Тусгай хаягдал: хаягдал тос, зуурмаг, тунадас, төмрийн будаг.

Булах ландфилл


Аюултай хог хаягдлыг булах (ландфилл)




Эмнэлгийн хог хаягдлыг инженерийн орчин үеийн шийдлээр, олон улсын стандартын дагуу байгаль орчин болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй технологиор төлөвлөгөөт менежментийн дагуу хүн хүч, техник тоног төхөөрөмж ашиглан газрын хөрсөнд булшлан устгаж, тухайн газрыг дахин ашиглах хүртэл авч хэрэгжүүлж буй инженерчлэлийн цогц байгууламжид булна.

Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Зураг 8. Төсөл хэрэгжих талбайн гадаргын төрх байдал, урдаас



Зураг 9. Төсөл хэрэгжих талбайн гадаргын төрх байдал, баруунаас



Зураг 10. Төсөл хэрэгжих талбайн гадаргын төрх байдал, хойноос

Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр



Зураг 11. Төсөл хэрэгжих талбайн гадаргын төрх байдал, зүүнээс



Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

1.3. Төслийн түүхий эд, бүтээгдэхүүн

Сандитис ХХК нь 8 ортой эмнэлэг, 38 эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллага, 19 амбулаторид эмнэлгүүдээс эмнэлгийн хог хаягдлыг цуглуулж тээвэрлэн устгана. Эрүүл мэндийн сайдын 2019 оны 605 тоот тушаалын норматив хэмжээг үндэслэн тооцсон ба ортой эмнэлгүүдээс хоногт 575.3 кг буюу жилд 206.82 тн хог хаягдал, Эмийн сан, Эм ханган нийлүүлэх байгууллагуудаас 6.84 тн хог хаягдал, Амбулаторид эмнэлгүүдээс 7.74 тн нийт 221.4 тн хог хаягдлыг эмнэлгүүдээс цуглуулна.

Хүснэгт 4. Ортой эмнэлгүүдээс гарах хаягдлын хэмжээ

	Эмнэлгүүдийн нэрс	1 хоногт гарах эмнэлгийн хог хаягдал Жин (кг)	30 хоногт гарах эмнэлгийн хог хаягдал Жин (кг)	1 жилд гарах эмнэлгийн хог хаягдал Жин (кг)	1 жилд гарах эмнэлгийн хогны хэмжээ Жин (тонн)
1	Нурлы	15	450	5,400	5.4
2	Фатиха	13	390	4,680	4.68
3	Нур- Алтай	9.5	285	3,420	3.42
4	Бейс- Шипа	11.5	345	4,140	4.14
5	Шарапат	11.5	345	4,140	4.14
6	Сансар сувилал	12.8	360	4,320	4.32
7	0165-р цэргийн анги	2	60	720	0.72
8	БӨ аймаг Нэгдсэн эмнэлэг	500	15,000	180,000	180
	НИЙТ ДҮН	575.3	17,235	206,820	206.82

Хүснэгт 5. Эмийн сан, Эм ханган нийлүүлэх байгууллагуудаас гарах хаягдлын хэмжээ

	Нэрс	1 хоногт гарах эмнэлгийн хог хаягдал Жин (кг)	30 хоногт гарах эмнэлгийн хог хаягдал Жин (кг)	1 жилд гарах эмнэлгийн хог хаягдал Жин (кг)
1	Аршаты	0,5	15	180
2	Байбулган	0,5	15	180
3	Ахмад	0,5	15	180
4	Ушкын	0,5	15	180

Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

5	Ермика	0,5	15	180
6	Могойт	0,5	15	180
7	Жалбыз	0,5	15	180
8	Мөнхийн тун	0,5	15	180
9	Моносфарм	0,5	15	180
10	Уужим	0,5	15	180
11	Еланфарм	0,5	15	180
12	МЭИК	0,5	15	180
13	Энэрэл	0,5	15	180
14	Дара	0,5	15	180
15	Жандауа	0,5	15	180
16	Ажар	0,5	15	180
17	Өлгий тун эм хангах	0,5	15	180
18	Монос эм хангах	0,5	15	180
19	Мөнхийн тун эм хангах	0,5	15	180
20	Эмимпекс эм хангах	0,5	15	180
21	Дармек	0,5	15	180
22	Харахат	0,5	15	180
23	Наз Дарумен	0,5	15	180
24	Кос кос	0,5	15	180
25	Яргуй	0,5	15	180
26	Фарфат	0,5	15	180
27	Алау	0,5	15	180
28	Шегиртай фарм	0,5	15	180
29	Айс ану	0,5	15	180
30	Нурлы	0,5	15	180
31	Элиф	0,5	15	180
32	Алпамет	0,5	15	180
33	Амирфарм	0,5	15	180
34	Дуалы	0,5	15	180
35	Мед	0,5	15	180
36	Биофарм	0,5	15	180
37	Дармек2	0,5	15	180
38	Сая фарм	0,5	15	180
НИЙТ ДҮН		19	570	6,840

Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 6. Амбулаторит эмнэлэгүүдээс гарах хаягдлын хэмжээ

	Эмнэлгүүдийн нэрс	1 хоногт гарах эмнэлгийн хогны хэмжээ Жин (кг)	30 хоногт гарах эмнэлгийн хогны хэмжээ Жин (кг)	1 жилд гарах эмнэлгийн хогны хэмжээ Жин (кг)
1	Азу-тис	1.05	31.5	378
2	Маржан	1.05	31.5	378
3	Сандитис	1.05	31.5	378
4	Хосхүү-дент	1.05	31.5	378
5	Ахмеруерт- тис	1.05	31.5	378
6	Шамшырах	1.05	31.5	378
7	Амингоомед	1.5	45	540
8	Астма	1.05	31.5	378
9	Инкар	1.05	31.5	378
10	Лале-мед	1.5	45	540
11	Жасминдент	1.05	31.5	378
12	Жанмед	1.5	45	540
13	Амьдсувд	1.05	31.5	378
14	Цахирбаянмед	1.05	31.5	378
15	Асылмед	1.05	31.5	378
16	Жансая өрхийн/Э	2.0	60	720
17	Мейрим өрхийн/Э	2.0	60	720
18	Рауан өрхийн/Э	2.0	60	720
19	Шипагер өрхийн/Э	2.0	60	720
НИЙТ		23.1	753	7,740

Хүснэгт 7. Нийт эмнэлэгүүдээс гарах хаягдлын хэмжээ

	Нэрс	1 хоногт гарах эмнэлгийн хог хаягдал Жин (кг)	30 хоногт гарах эмнэлгийн хог хаягдал Жин (кг)	1 жилд гарах эмнэлгийн хог хаягдал Жин (кг)	1 жилд гарах эмнэлгийн хогны хэмжээ Жин (тонн)
1	Ортой эмнэлгүүд	575.3	17,235	206,820	
2	Амб эмнэлгүүд	23.1	753	7,740	
3	Эмийн сан, эм хангах	19	570	6,840	
НИЙТ ДҮН		617.4	18,558	221,400	221.4

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Байгаль, цаг уур: Төслийн талбай байрлах нутаг дэвсгэр нь байрлалаараа дэлхийн бөмбөрцгийн хойт хагасын дундад өргөрөгт багтдаг учир эх газрын эрс тэс уур амьсгалтай. Тиймээс жилийн болон хоногийн агаарын дундаж температурын хэлбэлзэл өндөр, дулааны болон хүйтний өөрчлөлт шилжилт огцом байдаг. Далайн төвшнөөс их өндөрт оршдогоос сэрүүн уур амьсгалтай, хүрээлэн оршдог өндөр уулс гаднаас агаарын урсгалаар ирсэн чийгийг биедээ татдаг учир Алтайн нурууны өндөрлөг хэсэгт хур тунадасны жилийн дундаж хэмжээ 400-500 мм-д хүрдэг байна. Жилийн агаарын дундаж чийгшил 52.7%. Салхины чиглэл Х, БХ, Б-с хурд нь 9-25м\сек байх ба салхины ихэнх нь хавар намрын улиралд тохиолдоно.

Газрын гадарга

Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламж нь Баян-Өлгий аймгийн төвлөрсөн хогийн цэгийн талбайд 1.6 га газрыг нөхөн сэргээн, цэвэрлэж Бугат сумын засаг даргын 2023 оны 10 сарын 04-нй өдрийн 0000225072 тоот газар эзэмших гэрчилгээтэй газарт үйл ажиллагаа явуулж байна. Газрын гадаргын хувьд тэгш талархаг, усан сүлжээ, гуу жалга, мод сөөг байхгүй байна. Ерөнхий гадаргын хэлбэр хуучин хогийн цэг байсан нөлөөллийн улмаас унаган төрхөө бүрэн алдсан, гадаргын өнгөн хөрс элэгдэл эвдрэлд орж, ургамлан нөмрөггүй болсон байна.

Ургамлын бүрхэвч:

Төсөл хэрэгжих талбай нь ургамал газар зүйн мужлалтаар Евроазийн хээрийн их мужийн Төв Азийн муж Монгол Алтайн уулын дэд мужид хамаарна. Төслийн талбай орчимд Чулуусаг алаг өвс, ерөгт хуурай хээрийн ургамалжилттай. *Agropyron cristatum*, *allium eduardii*, *potentilla sericea*, *arenaria meyeri* зэрэг бүлгэмдэлтэй. Агь, таана, хөмүүл, шаваг, шарилж, ерхөг, хиаг, хазаар өвс, харгана, хялгана, бударгана зэрэг хээр, цөлөрхөг хээрийн өвс ургамал зонхилж, чийг илүүтэй уулын сүүдэр хажууд үхрийн нүд, хад, гүзээлзгэнэ, тошлой зэрэг зэрлэг жимсгэнэ ургадаг. Ой нь уулсын зөвхөн сүүдэр хажууг бүрхэн, өвөр хажуугаар хээрийн ургамал тархсан, уулархаг нутгаар вансэмбэрүү, бадамлянхуа, алтан гагнуур, чихэр өвс, бамбай, башиг, чийгийн давирхай, таван салаа, нохойн хошуу зэрэг эмийн ургамал

ургадаг боловч үйлдвэрлэлийн аргаар өргөн ашиглагдаггүй байна. Төслийн талбай дотор бичиглэл хийхэд дотор 10%-ийн ерөнхий бүрхэцтэй үетэн шарилжит төрөл тархсан байв. Үүнээс үзэхэд 1 м² талбайд 1-2 зүйл, 10 м² талбайд 1-2 зүйл ургамал тааралдах ба лууль, шарилж зэрэг ургамал тааралдана. Ургамлан бүрхэвчийн хувьд ургамлын бүрхэц 5% үетэн шарилжит бүлгэмдэл тархсан бөгөөд халцгахад чулуу ихтэй хуучин хогийн цэгийн газар байсны улмаас ургамлан нөмрөг бүрэн талхагдсан байна

Хөрсөн бүрхэвч:

Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Төв Азийн их мужийн Говийн мужийн өндрийн бүсшилтэй нутгийн Алтайн 56-р тойрогт хамаарах ба уулын цөлөрхөг хээрийн бор, хээрийн цайвар хүрэн хөрс зонхилон тархсан байна.

Хөрс нь I сул шүлтлэг, дээж II шүлтлэг урвалын орчинтой, I (15-30 см) дунд зэрэг карбонатлаг, бусад дээж бага зэрэг карбонаттай, ялзмагийн агууламжаар II (0-12 см) дунд зэрэг, бусад дээж бага зэрэг, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар 11 (0-12 см) дунд зэрэг, бусад дээж бага зэрэг байна. Хөрс нь саармаг урвалын орчинтой, карбонатын агууламжаар бага зэрэг, ялзмагийн агууламж маш бага, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар маш бага, солилцох сууриудын нийлбэр 0-10 см-т дунд, 10-30 см-т бага зэрэг байна. Механик бүрэлдэхүүн элсэнцэр механик бүрэлдэхүүн.

Задлан шинжилгээний дүнгээс үзэхэд хөрсөн дэх кадми илрээгүй харин элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй хөрсөн дэх хүлцэх агууламжаас хар тугалга, никель, зэс, цайрын агууламж MNS 5850:2019 стандарт хэмжээнээс давсан үзүүлэлт байхгүй байна.

Хөрсний дээжинд хөрсний эрүүл ахуйн шинжилгээг Хөрсний чанар, Хөрсөнд эрүүл ахуйн нян судлалын шинжилгээ хийх арга MNS6341:2012 стандартад заасан аргаар 0-15 см гүнд шинжилгээг хийсэн бөгөөд гарсан дүнг Байгаль Хөрс, Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ харьцуулахад гэдэсний савханцарын таныц 1.0 перфингенсийн таныц $0,1 <$ байна. Энэ нь бохирдолгүй байгааг илтгэнэ.

Тус төслийн талбайгаас авсан хөрсний дээжинд байгалийн болон үүсмэл цацраг идэвхт изотопуудын хувийн идэвхийг гамма спектрометрийн аргаар тодорхойлсон дүнгээс харахад хөрсний дээж дэх байгалийн цацраг идэвхт калийн дундаж агуулалт 488 байгаа нь дэлхийн

дундажаас 1.29 дахин их байна. Энэ нь тус төслийн талбай нь хог хаягдлын цэг байсантай холбоотойгоор үнс их хэмжээгээр байгаатай холбоотой гэж үзэж байна.

Ус зүй

Баян-Өлгий аймгийн район нь гидрогеологийн судалгааны хувьд муу судлагдсан гадаргын болон газар доорхи усан сүлжээ алаг цоог тархсан бүсэд хамаарахын зэрэгцээ дэлхийн усны хувьд гадагш урсгалгүй ай савд хамаардаг байна. Судалгааны талбайд аллювийн уст үе давхарга тархах бөгөөд талбайн зүүн талд хийсэн өмнөх судалгаагаар 6.0 метр гүнтэй өрөмдөхөд хөрсний ус 2.6-2.8 метрт илэрч тогтож байсан байна. (2013 оны 7-р сарын байдлаар).

Төслийн талбайтай хамгийн ойр байрлах айлын гүний худгаас дээж авч шинжлүүлэхэд “Химийн бүрэлдэхүүнээр сульфатын ангийн холимог бүлгийн 2-р төрлийн чанарын хувьд цэнгэгдүү, хатуу, хатуулаг дотроо магнийн ион зонхилсон ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүдээс ерөнхий хатуулаг болон магнийн ион нь “ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюудгүй байдлын үнэлгээ MNS0900:2018” стандартад заасан хэмжээнээс их байгаа учир зөөлрүүлж хэрэглэх хэрэгтэй”- тухай хариу гарсан¹.

¹ БОННУ-ний тайлан

3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

3.1.Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж

болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ

2025 онд эрүүл мэндийн байгууллагуудаас хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэлтийн үед тоосжилт үүсэж агаарыг бохирдуулахаар байна. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчинд хэсэгчилсэн бохирдолтыг бий болгоно.

3.2.Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын доорх ус бохирдох эрсдэлтэй. Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментийн дагуу явуулаагүйгээс болж гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй.

3.3.Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2025 онд эрүүл мэндийн байгууллагуудаас хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасна. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдож болзошгүй.

Хогийг дарж булах явцад байгалийн ландшафт өөрчлөгдөх бөгөөд тэр хэмжээгээр орчны доройтол, орчны бохирдол, бэлчээрийн доройтол үүснэ.

3.4.Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Үйлдвэрт ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, машин механизм, тээврийн хэрэгслийн гэрэлтүүлгээс болж шөнийн амьдралтай амьтад үргэн дайжиж болзошгүй.

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов.

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Засгийн газар, БОАЖЯ болон бусад холбогдох газруудаас гаргасан зохих заавар, журмын дагуу “МОНГОЛ ПЕРЛИТ КОНСТРАКШН” ХХК-ийн “Замын улаан” перлитийн ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав. Төсөл хэрэгжүүлэгч “МОНГОЛ ПЕРЛИТ КОНСТРАКШН” ХХК нь байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагааны сөрөг нөлөөллөө байгальд үзүүлж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлж ажиллана.

Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	9
1	Агаарын чанар Салхины хурд 10 м/с үед тээвэрлэлтийн замаас үүсэх тоосонцрын агууламж стандарт хэмжээнээс давж болзошгүй	Үйлдвэр болон эмнэлгүүд хүрэх зам талбайг услах	Тоос босох гадаргуу	Мот/цаг	2000000	Төслийн хугацаанд	- Агаарын тухай хууль - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - MNS 4585:2016 MNS 3384:82
		Тээврийн машин техникийн кабин доторх агааржуулах төхөөрөмж, хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч байх	Үйлдвэрийн бүх авто машинуудад	-	-	2025 он	
		Мөн агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.	Үйлдвэрийн талбай болон тээврийн маршрутын хэмжээнд	-	Хяналт шинжилгээний ажлын зардалд орсон	2025 он	
		Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу үйлдвэрт ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө. Үйлдвэрт ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүд байна.	Үйлдвэрт ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүд байна.	-	Уулын ажлын зардалд орсон	2025 он	
	Нийт	2000000					
2.	Гадаргын ба газрын доорх усны	Ус ашиглах гэрээгээ байгуулан төлбөрөө төлнө			1000000	2025 он	Усны тухай хууль MNS 900:2005 MNS 4943:2015

Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

	нөөц						MNS 5850:2008
		Үйлдвэрийн хашааг тойруулан үерийн далан байгуулах	Үйл ажиллагааны зардалд орно			2025 он	
		Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	Уст цэгт	Зардал нь хяналт шинжилгээний зардалд орсон		2025 он	
	Нийт	1 000 000					
3.	Газрын хэвлий болон Хөрсөн бүрхэвч	Газар эзэмших гэрээгээ сумын засаг даргатай байгуулах, төлбөрөө төлөх	Төслийн талбайн хэмжээнд	-	Үйл ажиллагааны зардалд	2025 он	MNS 5916:2008
		Автомашины зогсоолыг цементэн хучилттай болгох	Засварын талбай, авто зогсоол	-	1000000	2025 он	MNS 5917:2008 MNS 5918:2008
		Үйлдвэрийн ажилчдын бие засах газрыг Байгаль орчинд ээлтэй эко 00 барих	Үйлдвэрийн талбай		2000000		
	Нийт	3 00 0000					
4	Ургамлан нөмрөг болон Амьтны аймаг	Олон салаа зам гаргахгүй байна. Замын тэмдэг тэмдэглэгээ байршуулна	Үйлдвэрийн талбай болон тээврийн маршрутын хэмжээнд	-	500000	Төслийн хугацаанд	Амьтны тухай хууль - Байгаль орчныг хамгаалах тухай MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
		Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг үйлдвэрт байрлуулна.	Үйлдвэрийн талбай	-	500000	2025 он	
	Нийт		1 000 000				
5	Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал 7 000 000						

Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр


5. НОГООН БАЙГУУЛАМЖ БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, ТЭРБУМ МОД ХӨТӨЛБӨР

“Сандитис” ХХК нь 2025 онд орон нутгаас заасан чиглэлд буюу өөрийн төслийн талбайд 5 төрлийн 500 модыг тарихаар төлөвлөв.

Хүснэгт 9. Ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Сумын нутаг дэвсгэрт орон нутгаас заасан чиглэлийн дагуу	500 ш мод тарина	-	-	-	3000000	2025 онд	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
	Нийт					3 000 000		

Зураг 12. Ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө, 2025 он



Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

7. ХИМИЙН БОДИС ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төсөл нь химийн бодис ашиглахгүй. Тиймээс химийн бодисын менежментийн төлөвлөгөө хийгдэх шаардлагагүй гэж үзэж байна.

8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, үйлдвэрийн ажилчдын хэрэгцээнээс хаягдах бохир ус, үйлдвэрийн техникийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдал ус, техникт ашигласан хаягдал тос зэргээс бүрдэж байна.

Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно.

Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хог Хаягдал	Ахуйн хатуу хог хаягдлыг сумын ТҮК-тэй гэрээ байгуулан зөөвөрлөх	Баян-Өлгий аймгийн нэгдсэн хогийн цэгт хогоо нийлүүлэх,	кг	-	-	Үйлдвэрийн дотоод зардалд орсон.	Хог хаягдлын тухай хууль
		Ахуйн хатуу хог хаягдлаа төрөлжүүлэн ялган ангилах хогийн савнуудыг худалдан авч хог хаягдлын төрлийг хогийн савны гадна бичиж байрлуулна.	Ажилчдын байрны гадна байршуулах	тоо	100 000	3	300 000	
		Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	Хог хаягдлын цэг	М²	500 000	0.3	500 000	
2	Аюултай хог хаягдал	Машинаас гарсан хаягдал, гос масло болон гарсан дугуй, гэрлийн шил, бусад сэлбэгийн хог хаягдал, хуванцар сав зэргийг ангилан ялгаж, хаягдал боловсруулах үйлдвэр, дахивар авах цэгт нийлүүлэх	Төслийн талбайд	тоо	300 000	-	200 000	
Нийт зардал				1 000 000				

10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БАЙГАЛИЙН АЮУЛ, ГАМШИГ

Аянга цахилгаан: Дулааны улиралд тохиолдох бөгөөд цаг агаарын мэдээг тогтмол мэдээлэх хэрэгтэй. Цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг стандартын дагуу газардуулсан байх, ил задгай цахилгааны утас зэрэг аянга үүсэж болзошгүй зүйлүүдийг хамгаална.

Газар хөдлөлт: Газар хөдлөлтийн мужлалаар төсөл хэрэгжих газар нь 6 баллын бүсэд хамаарна. Иймээс барилга байгууламж барихдаа зураг төслийн дагуу эрсдэлийг нарийвчлан авч үзэх шаардлагатай. Мөн ашиглалтын явцад газар хөдлөлтийн үед авах арга хэмжээг боловсруулна. Салхины хурдыг багасгах хаах тоос шороог багасгах зорилгоор салхины зонхилох чиглэлд ногоон байгууламжуудыг бий болгоно. Тээврийн замыг тогтмол арчилж, усалгаа хийж чийгшүүлж байх. Ажлын байрны эрүүл ахуйн хяналтыг системийг бийболгох. Онц байдалд үйл ажиллагааг зогсоох тухай журам боловсруулж мөрдөнө.

Шороон шуурга: Салхины хурдыг багасгах хаах тоос шороог багасгах зорилгоор салхины зонхилох чиглэлд ногоон байгууламжуудыг бий болгох. Тээврийн замыг тогтмол арчилж, усалгаа хийж чийгшүүлж байх. Ажлын байрны эрүүл ахуйн хяналтыг системийг бийболгох. Онц байдалд үйл ажиллагааг зогсоох тухай журам боловсруулж мөрдөх Халдварт өвчин: Үйлдвэрийн ажилчдад хууль бус ан агнахгүй байх түүнээс үүдэн гарах сөрөг нөлөөллийн талаар сургалт явуулах, хамгаалалтын хэрэгслээр хангах (амны хаалт г.м), аймгийн эрүүл мэндийн төвтэй харилцаа холбоотой байж мэдээлэл авч байна.

Гал түймэр: Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, зааварчилгаа, хяналтын ажил, гал гарсан үед түүнийг унтраах хэрэгслийн хангамж, цахилгаан тоног төхөөрөмж дээр ажиллах үд мөрдөх аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх арга хэмжээг МУ-н “Галын аюулгүй байдлын тухай хууль”, “Аж ахуй нэгж байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүй байдлын дүрэм”, “Гал түймрийн аюулгүй байдалтай холбогдуулан гаргасан тушаал, шийдвэрийн дагуу зохион явуулна

Авто тээврийн осол: Машин техникийн засвар үйлчилгээг тогтмол хийх, ажлын байрны үзлэг шалгалтыг байнга хийх. Ажилчдын аюулгүй ажиллагааны сургалтад тогтмол хамруулах. Зам тээвэрт хурдны хязгаар тогтоож, тэмдэг тэмдэглэгээг сайн хийх, замын хөдөлгөөний аюулгүй дүрмийг чанд баримтлан ажиллана.

11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь Баян-Өлгий аймгийн Өлгий сумын нутагт хэрэгжиж буй Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламж төслийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон түүний үйл ажиллагааны явцад гарч болзошгүй эрсдэлийн үед байгаль орчинд бий болох бохирдол, доройтлыг тодорхойлох зорилготой заавал хэрэгжүүлэх баримт бичиг юм.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж үр дүнг нь доорх асуудлуудыг тодорхойлох, үнэлэхэд ашиглана. Үүнд:

- Анх таамагласан сөрөг нөлөөллүүдийн хэмжээ, үр дагавраас бодит сөрөг нөлөөлөл, түүний үр дагавар хир зөрж байгааг
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт болон холбогдох эрх зүйн баримт бичиг, стандарт, дүрэм журамтай нийцэж байгаа эсэхийг
- Нөлөөллүүдийн эрчим, буурах эсвэл нэмэгдэж байгаа
- Төслийн БОМТ-ний нийт үр ашгийг үнэлэх зэрэг орно.

Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр


шинж илгээ хийх	Хэмжих нэгж	Хугацаа ба давтамж	Нэгжийн н өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Агаарын чанар	Тоосонцор: TSP, PM2.5, PM10	1 удаа	-	-	MNS 4585:2016 MNS 6063:2010
	SO _x NO _x CO _x		80.0	160.0	MNS 5002:2000 MNS 3113:1981 MNS 5885:2008
	Дуу чимээ чичиргээ, доргио		-	-	Агаарын тухай хууль Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
	Нийт зардал			160.0	
Хөрсөн бүрхэвч	- Механик бүрэлдэхүүн - Хими, физикийн шинж чанар - Бохирдол - Хүнд металл /Pb, Cd, Hg, As, Cr,.../ - Нефтийн бүтээгдэхүүн - Бактереологи	1 удаа	65.0	130.0	MNS 5850 : 2008 MNS 3298 : 1991 MNS 5546 : 2005 MNS 3985 – 87 MNS 2305 - 94
	Нийт зардал			130.0	
Ус	- Хүнд металл - Анион, катион - Бактереологи - Худаг, цооногуудын усны түвшин, түүний өөрчлөлт	1 удаа	20.0	60.0	MNS 3934:1986 MNS /ISO/ 5667-11:2000 MNS / ISO / 5667-11:2000 MNS 6148:2010 MNS 5667:10:2001 MNS 6148:2010 MNS /ISO/ 5667-11:2000 MNS 3934:1986 MNS /ISO/ 5667-11:2000 MNS 4943:2011

Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

					MNS 900:2005 Усны тухай хууль
	Нийт зардал			60.0	
	Орчны хяналт шинжилгээний тайлан боловсруулах зардал	1 удаа		2000.0	
	НИЙТ ЗАРДАЛ			2350.0	

Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Зураг 13. Мониторингийн байршлын зураг



12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавьж ажиллана.

Хүснэгт 12. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Ажилчдын мэдлэг чадвар дутмаг байдлаас ажлын доголдол гарах	Үйлдвэрт ажиллаж байгаа ажиллагсдын тухайн ажлыг хийж гүйцэтгэх мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор мэргэжлийн сургаалтанд хамруулж байх	Ажилчид	1000000	Жил бүр	МУ-ын үндсэн хууль Хөдөлмөрийн тухай Эрүүл мэндийн тухай Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм MNS 4990:2000 MNS 4968:2000 MNS 4994:2000
Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх		Тусгай зөвшөөрлийн талбайд	3000000		
Үйлдвэрийн үйл ажиллагаанаас ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй	Ажлын байрны хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилчдыг илчлэг, витаминлаг хоол хүнсээр хангах	Бүх ажилчдыг	Үйл ажиллагаан ы зардалд орсон	Өдөр бүр	
			4000000		

Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ

Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх арга хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Төслийн талбайн ойролцоох иргэд болон төсөл хэрэгжиж буй баг, сонирхогч талууд, засаг захиргааны ажилчид	Төслийн талаарх мэдээллийг цаасан болон presentation хэлбэрээр тайлагнах, хэлэлцэх	Төслийн техник технологи, ажилчид, бусад үйл ажиллагааны талаарх мэдээлэл, төслөөс байгаль орчин болон нийгэм эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлсэн эерэг, сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах багасгах чиглэлээр хийсэн арга хэмжээ, байгаль хамгаалах, ногоон байгууламж, мод тарисан ажлын тухай	Жилд 1 удаа. 10-11 сард.	Төслийн үйл ажиллагаагаар ойролцоох иргэд амьдрал ахуй, эрүүл мэнд, нийгэмд үзүүлсэн эерэг, сөрөг нөлөө, сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах чиглэлээр хэрэгжүүлбэл зохистой арга хэмжээ, төслийн үйл ажиллагааны талаарх санал бодлыг сонсох	Багийн эсвэл сумын төв
Зардал, мян.төг					500000

БОМТ-ний биелэлтийн тайланг тухайн оны 12 сарын 10-ний дотор БОАЖЯаманд ирүүлэх ба үүнээс өмнө хуваарийн дагуу орон нутгийн иргэд, засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчид, сонирхогч талуудад танилцуулж хэлэлцүүлэн тэдний санал бодлыг тайланд тусгасан байна.

Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах “Сандитис” ХХК-ийн Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах байгууламжийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв

Хүснэгт 14. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

Д.д	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	7000.0
2	Тэр бум мод ажлын зардал	3000.0
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1000.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2350.0
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1000.0
7	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	4000.0
2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн		18350.0

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө нөхөн сэргээх арга хэмжээнд нийт **18.35 сая** төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Үүний 50 хувь 9.175 сая төгрөг байна. Бид Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.15 дахь заалтад зааснаар Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулна.